## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дашинчилэн сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** БУА-2026/147/НА-СА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг

2026 он


Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Батцогт Утас: 89008258
Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn

Аудитын менежр: Ж.Энхцоодол Утас: 7034-2580
Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид
Утас: 9511-2689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Ахлах аудитор Ш.Ганчимэг Утас: 9937-7360
Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn


2026.02.24 № 253

танай ______ ны № ______ т

ДАШИНЧИЛЭН СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Н.АЛИМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Дашинчилэн сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашинчилэн сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

Дашинчилэн сумын Цэцэрлэг нь тайлант онд өмнөх оны үлдэгдэл 169.3 сая, улсын төсвөөс 634.7 сая төгрөгийн санхүүжилт авч, 740.9 сая төгрөг зарцуулж, 63.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. Нийт зардлын 639.1 сая төгрөг буюу 86.2 хувь нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл байна.

**Бусад асуудлын хэсэг**

Дашинчилэн сумын Цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 52 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлийг аймгийн Боловсролын газар 76.6 хувиар дүгнэсэн байна.

6326050329

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **227,897,372.28** | **132,873,072.56** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **169,286,622.28** | **63,106,806.56** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **169,286,622.28** | **63,106,806.56** |
| **3121** | **Төгрөг** | **169,286,622.28** | **63,106,806.56** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 169,286,622.28 | 63,106,806.56 |
| **33** | **АВЛАГА** | - | **378,716.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 378,716.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **58,610,750.00** | **69,387,550.00** |
| **351** | **Түүхий эд материал** | **180,000.00** | **180,000.00** |
| 35130 | Эм боох материал | 180,000.00 | 180,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **58,430,750.00** | **69,207,550.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,517,900.00 | 1,542,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 49,180,300.00 | 57,413,450.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,430,050.00 | 7,949,200.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,302,500.00 | 2,302,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **662,257,301.65** | **661,364,426.12** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **662,257,301.65** | **661,364,426.12** |
| **392** | **Биет хөрөнгө** | **651,820,801.68** | **651,012,301.15** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 904,442,293.38 | 904,442,293.38 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (363,051,763.63) | (370,800,543.73) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 59,266,530.00 | 62,805,530.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (18,449,835.46) | (21,055,041.18) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 63,817,175.50 | 73,457,175.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (22,152,178.15) | (24,123,262.87) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 33,017,600.00 | 33,017,600.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (5,069,019.96) | (6,731,449.95) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **10,436,499.97** | **10,352,124.97** |
| 39301 | Програм хангамж | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (757,500.03) | (841,875.03) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,844,000.00 | 9,844,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **890,154,673.93** | **794,237,498.68** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **2,432,100.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **2,432,100.00** |
| **413** | **Өглөг** | **-** | **2,432,100.00** |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 2,432,100.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **890,154,673.93** | **791,805,398.68** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **890,154,673.93** | **791,805,398.68** |
| 511 | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | **104,700,853.35** | **104,700,853.35** |
| 51101 | Өмч: - төрийн | 9,844,000.00 | 9,844,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **578,134,511.46** | **479,785,236.21** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 578,134,511.46 | 578,134,511.46 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (98,349,275.25) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 207,319,309.12 | 207,319,309.12 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **890,154,673.93** | **794,237,498.68** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **747,516,634.00** | **785,583,050.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **46,907,534.00** | **66,033,950.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **46,907,534.00** | **66,033,950.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | **46,907,534.00** | **66,033,950.00** |
| 1200044 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө | 11,744,250.00 | 13,179,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал | 46,907,534.00 | 52,854,950.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **700,609,100.00** | **719,549,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **668,729,100.00** | **634,669,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 668,729,100.00 | 634,669,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **31,880,000.00** | **84,880,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,880,000.00 | 84,880,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **664,247,131.17** | **883,932,325.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **664,247,131.17** | **883,932,325.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **664,109,422.51** | **883,923,254.61** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **453,920,273.00** | **570,770,092.11** |
| 210101 | Үндсэн цалин | 297,869,670.00 | 364,048,423.55 |
| 210102 | Нэмэгдэл | 131,908,078.00 | 161,297,402.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 16,905,000.00 |
| 210104 | Урамшуулал | 24,142,525.00 | 28,519,266.56 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **62,741,893.73** | **67,985,607.61** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,335,383.08 | 46,347,146.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,853,663.96 | 5,374,714.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,804,557.64 | 2,835,311.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,313,452.44 | 2,688,307.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,434,836.61 | 10,740,128.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **29,942,291.34** | **42,306,129.36** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,221,473.34 | 10,999,129.36 |
| 210302 | Түлш, халаалт | 10,540,818.00 | 31,107,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 180,000.00 | 200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | **1,189,600.00** |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 1,189,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **67,523,570.00** | **69,304,800.00** |
| 210502 | Хоол, хүнс | 67,523,570.00 | 69,304,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | **44,996,900.00** |
| 210604 | Урсгал засвар | - | 44,996,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **891,600.00** | **3,263,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 891,600.00 | 3,263,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **49,089,794.44** | **84,107,125.53** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,578,050.00 | 56,752,450.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,262,350.00 | 13,282,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 17,249,394.44 | 14,071,875.53 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **137,708.66** | **9,070.64** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **137,708.66** | **9,070.64** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 137,708.66 | 9,070.64 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **95,013,752.83** | **(98,349,275.25)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **4,870,000.00** | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 4,870,000.00 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(4,870,000.00)** | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **90,143,752.83** | **(98,349,275.25)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **700,609,100.00** | **719,549,100.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **700,609,100.00** | **719,549,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **668,729,100.00** | **634,669,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 668,729,100.00 | 634,669,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **31,880,000.00** | **84,880,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,880,000.00 | 84,880,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **647,925,886.73** | **825,728,915.72** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **647,925,886.73** | **825,728,915.72** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **647,788,178.07** | **825,719,845.08** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **458,552,390.00** | **571,148,808.11** |
| 210101 | Үндсэн цалин | 297,869,670.00 | 364,427,139.55 |
| 210102 | Нэмэгдэл | 131,908,078.00 | 161,297,402.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 16,905,000.00 |
| 210104 | Урамшуулал | 28,774,642.00 | 28,519,266.56 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **58,109,776.73** | **67,985,607.61** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,157,483.19 | 46,347,146.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,496,532.82 | 5,374,714.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,594,709.67 | 2,835,311.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,142,688.67 | 2,688,307.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,718,362.38 | 10,740,128.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **29,942,291.34** | **39,874,029.36** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,759,019.34 | 10,999,129.36 |
| 210302 | Түлш, халаалт | 22,003,272.00 | 28,674,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 180,000.00 | 200,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **65,611,020.00** | **72,823,950.00** |
| 210502 | Хоол, хүнс | 65,611,020.00 | 72,823,950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,800,000.00** | **44,996,900.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,800,000.00 | 44,996,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,224,000.00** | **3,591,900.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,224,000.00 | 3,591,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **31,548,700.00** | **25,298,650.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,060,300.00 | 19,159,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,488,400.00 | 6,139,650.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **137,708.66** | **9,070.64** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **137,708.66** | **9,070.64** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 137,708.66 | 9,070.64 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **52,683,213.27** | **(106,179,815.72)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 52,683,213.27 | (106,179,815.72) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **169,286,622.28** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **169,286,622.28** | **63,106,806.56** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - | - |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **-** | - |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **-** | - |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **104,700,853.35** | **207,319,309.12** | **578,134,511.46** | **890,154,673.93** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **-** | - |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (98,349,275.25) | (98,349,275.25) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **104,700,853.35** | **207,319,309.12** | **479,785,236.21** | **791,805,398.68** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **788,170,700.0** | **825,728,915.72** | **(37,558,215.72)** | **104.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **788,170,700.0** | **825,728,915.72** | **(37,558,215.72)** | **104.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **788,170,700.0** | **825,719,845.08** | **(37,549,145.08)** | **104.76** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **608,039,300.0** | **571,148,808.11** | **36,890,491.89** | **93.93** |
| 210101 | Үндсэн цалин | 393,218,500.0 | 364,427,139.55 | 28,791,360.45 | 92.68 |
| 210102 | Нэмэгдэл | 192,922,700.0 | 161,297,402.0 | 31,625,298.0 | 83.61 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 16,905,000.0 | (16,905,000.0) | |
| 210104 | Урамшуулал | 21,898,100.0 | 28,519,266.56 | (6,621,166.56) | 130.24 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **75,642,600.0** | **67,985,607,61** | **7,656,992.39** | **89.88** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,321,200.0 | 46,347,146.71 | 4,974,053.29 | 90.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,080,400.0 | 5,374,714.0 | 705,686.0 | 88.39 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,040,100.0 | 2,835,311.90 | 204,788.10 | 93.26 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,040,100.0 | 2,688,307.0 | 351,793.0 | 88.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,160,800.0 | 10,740,128.0 | 1,420,672.0 | 88.32 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **39,874,029.36** | **39,874,029.36** | |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 10,999,129.36 | 10,999,129.36 | |
| 210302 | Түлш, халаалт | | 28,674,900.0 | 28,674,900.0 | |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 200,000.0 | (200,000.0) | |
| **2105** | **Нормативт зардал** | **74,856,300.0** | **72,823,950.0** | **2,032,350.0** | **97.28** |
| 210502 | Хоол, хүнс | 74,856,300.0 | 72,823,950.0 | 2,032,500.0 | 97.28 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **44,996,900.0** | **(44,996,900.0)** | |
| 210604 | Урсгал засвар | | **44,996,900.0** | **(44,996,900.0)** | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,591,900.0** | **3,591,900.0** | | **100.0** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | **3,591,900.0** | **3,591,900.0** | | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **26,040,600.0** | **25,298,650.0** | **741,950.0** | **97.15** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19.894,600.0 | 19,159,000.0 | 735,600.0 | 96.30 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,146,000.0 | 6,139,650.0 | 6,350.0 | 99.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **9,070.64** | **9,070.64** | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | | | |
| | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 9,070.64 | (9,070.64) | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 9,070.64 | (9,070.64) | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | | | |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | | | |
| 222001 | Тоног төхөөрөмж | | | | |
| 223001 | Бусад хөрөнгө | | | | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | | | | |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | 634,669,100.0 | (634,669,100.0) | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | | | | |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | | 84,880,000.0 | (84,880,000.0) | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | | | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | | |
| 4 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **169,286,622.28** | **(169,286,622.28 )** | |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **63,106,806.56** | **(63,106,806.56)** | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 48,077.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 45,375.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 871.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 654.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,176.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

1. Ажилтны ээлжийн амралтын хугацаанд цалин хөлс давхардуулан 871.0 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг тус тус зөрчсөн тул Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3 заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Албан шаардлага

1. Цэцэрлэгийн эрхлэгч Н.Алимаад аймгийн Боловсролын газрын даргын 2025.10.08-ны өдрийн А/104 дүгээр тушаалыг үндэслэн батлагдаагүй орон тооны ХАБ-ын ажлыг хавсран гүйцэтгүүлж 40 хувийн нэмэгдэл хөлсөнд 654.8 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В-д заасантай тус тус нийцэхгүй байгаа тул Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д заасныг үндэслэн албан шаардлага өгсөн.

### 3.3 Зөвлөмж

1. *Илрүүлэлт:*

Эрхлэгчийн 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Б/26 тоот тушаалаар санхүүийн үйл ажиллагааг хавсран гүйцэтгэдэг нягтлан бодогч болон нярав нарт жилийн эцсийн тайлан баланс хангалттай дүгнүүлсэн үндэслэлээр 1,176.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардсан.

*Өгсөн зөвлөмж*:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийн хөрөнгийн үр дүнг сайжруулах, зөв зохистой удирдах зарчмыг баримтлан бусад шагнал урамшууллыг төрийн албан хаагчийн үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгож байгаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. *<u>Илрүүлэлт:</u>*

Нягтлан бодогч нь санхүүгийн СиТиЭс программаар тайлан тэнцэл гаргаж байгаа бөгөөд журналын бүртгэл хоорондын уялдааг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*:

Нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүллээ.

3. *<u>Илрүүлэлт</u>*

Жилийн эцсийн эд хөрөнгийг тооллогод бүрэн хамруулаагүй, хүнсний болон аж ахуйн материалын тооллого хийгдээгүй, тооцоо бодсон актыг бүрэн хөтлөөгүй.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*:

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд чанартай хийж, үр дүнд тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | Үүнээс | | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ХАОАТ-ын авлага тайланд тусгаагүй. | 1 | 378.7 | | | 1 378.7 | 1 | 378.7 | | | | | |
| Урсгал засварын зориулалтаар худалдан авч авч зарцуулсан бараа материалыг няравын тайланд тусгаагүй шууд зардалд бичсэн. | 1 | 44,996.9 | 1 | 44,996.9 | | 1 | 44,996.9 | | | | | |
| Дүн | 2 | 45,375.6 | 1 | 44,996.9 | 1 378.7 | 2 | 45,375.6 | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс |
|---|---|---|

| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ээлжийн амралтын хугацаанд цалин тооцож олгосон. | 1 | 871.0 | 1 | 871.0 | | | | | | | | |
| Цэцэрлэгийн эрхлэгч Н.Алимаад батлагдаагүй орон тооны ХАБ-ын ажилтны хавсран ажилласны 40 хувийн нэмэгдэл хөлс олгосон. | 1 | 654.8 | | | 1 | 654.8 | | | | | | |
| Үр дүнгийн шагнал урамшуулалтай холбоотой зөрчил | 1 | 1,176.1 | | | | | 1 | 1,176.1 | | | | |
| Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Жилийн эцсийн хөрөнгийн тооллоготой холбоотой | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Дүн | 5 | 2,701.9 | 1 | 871.0 | 1 | 654.8 | 3 | 1,176.1 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

## ААБ 5.5. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Дашинчилэн сумын цэцэрлэг

Байгууллагын РД: 9011315

Аудитын код: БУА 2026/147 /НА-СТА-ТШЗ

Аудитын нэр: Санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаа: 2025.01.01-2025.12.31

Хүснэгт А. Эрсдэлтэй АГАДҮТ-ын үүсгэсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх

| ДА | АГАДҮТ | АГАДҮТ-ын дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт | | Алдаа зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Байгууллагын санал тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Стандарт заалт | Хууль тогтоомжийн заалт | | | | | |
| 1 | | МХ | Цэцэрлэгийн эрхлэгч Н.Алимаад батлагдаагүй орон тооны ХАБ-ын ажилтны хавсран ажилласны нэмэгдэл илүү олгосон | 654,600.00 | Материаллаг | Тийм | УСНББОУС 1 | Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах. Аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/114 дүгээр тушаал | Хууль тогтоомжийн заалттай холбоотой | Албан шаардлага хүргүүлэх | Зөвшөөрсөн | Албан шаардлага хүргүүлэх | Албан шаардлага хүргүүлэх |
| 2 | | МХ | Эрхлэгчийн 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Б/26 тоот тушаалаар санхүүгийн үйл ажиллагааг хавсран гүйцэтгэдэг нягтлан бодогч болон нярав нарт жилийн эцсийн тайлан баланс хангалттай дүгнүүлсэн гэх үндэслэлээр урамшуулалт цалин олгосон | 1,176,100.00 | Материаллаг | Тийм | УСНББОУС 1 | Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах | Хууль тогтоомжийн заалттай холбоотой | Зөвлөмж өгөх | Зөвшөөрсөн | Зөвлөмж өгөх | Зөвлөмж өгөх |
| 3 | | МХ | Жижүүр Б.Чимэд, тогооч Л.Болорцэцэг нарт ээлжийн амралтын хугацаанд цалин давхардуулан олгосон | 871,043.00 | Материаллаг | Тийм | УСНББОУС 1 | Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах | Хууль тогтоомжийн заалттай холбоотой | Төлбөрийн акт тогтоох | Зөвшөөрсөн | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоох |

ЦЭСБ-АУДИТ ХХК
ДУГААР-02

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | | БТ | Нягтлан бодогч нь санхүүгийн СиТиЭс программаар тайлан тэнцэл гаргаж байгаа бөгөөд журналын бүртгэл хоорондын уялдаа бүрэн хэрэгжүүлж дэвтэлгүй байна | | Материаллаг бус | Үгүй | УСНББОУС 20 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт эрх бүхий байгууллагаас баталсан ННБүртгэлийн стандарт, журам заавар энэ хуулийн 5 д заасан заасан нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтлөж санхүүгийн тайлан гаргах", 6-д "ААН нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ анхдагч суурьтаар хөтөлнө" | ННБүртгэлийн Хууль тогтоомжийн заалттай холбоотой | Зөвлөмж өгөх | Зөвшөөрсөн | Зөвлөмж өгөх | Зөвлөмж өгөх |
| 6 | | БМ | Жилийн эцсийн эд хөрөнгийг тооллогод бүрэн хамруулаагүй, хүчний болон эд дэлгэн материалын тооллого хийгдээгүй, тооцоо бодсон актыг бүрэн нягтлаагүй | 2701948.- | Материаллаг бус | Тийм | УСНББОУС 12 | Нягтлан бодох бүртгэлийн бүртгэлийн тухай хуулийн 12.2.1-д "Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргасны өмнө" | Хууль тогтоомжийн заалттай холбоотой | Зөвлөмж өгөх | Зөвшөөрсөн | Зөвлөмж өгөх | Зөвлөмж өгөх |
| | | | | | | | | | | | | | |
| | | **Нийт дүн** | | 2701948 | | | | | | | | | |

Бэлтгэсэн:

ЦЭСБ аудит ХХК-ийн Ахлах аудитор Ш Ганчимэг Огноо 2026.01.23.

Хянасан: Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д Батцогт

Аудитын менежер Ж Энхцоодол

Танилцаж зөвшөөрсөн:

Цэцэрлэгийн эрхлэгч Н Алимаа Огноо:

Нягтлан бодогч З Отгонтуяа Огноо

Нийт дүн залруулсан 2701948 төг

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**ТӨЛБӨРИЙН АКТ**

2026 оны 02 дугаар сарын 25 Дугаар 01/179 Булган сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дашинчилэн сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус Цэцэрлэгийн жижүүр Б.Чимэд, тогооч Л.Болорцэцэг нарт ээлжийн амралтын хугацаанд 871,043.00 (найман зуун далан нэгэн мянга дөчин гурав) төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.2-т *"Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д *"Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна."* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д *"Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"* гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 871,043.00 (найман зуун далан нэгэн мянга дөчин гурав) төгрөгийг Булган аймгийн төрийн сангийн төсвийн орлогын Бу.Аудит-орлого (РД:9039001) MN390090100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дашинчилэн сумын Цэцэрлэгийн эрхлэгч (Н.Алимаа), нягтлан бодогч (З.Отгонтуяа) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙ АУДИТОР Ш.ГАНЧИМЭГ

Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 410 тоот өрөө, утас-70342716

6326110561

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН**
**ШААРДЛАГА**

2026 оны 02 дугаар сарын 25 Дугаар 01/18 - 2/2020282 Буга-2026/147/НА-СТА-ТШЗ Булган сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дашинчилэн сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус Цэцэрлэгийн эрхлэгч Н.Алимаад аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/104 дүгээр тушаалыг үндэслэн батлагдаагүй орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хэлсэнд 654,800.00 (зургаан зуун тавин дөрвөн мянга найман зуу) төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "*Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах*", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "*Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна*", 27.6-д "*Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална*", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт "*Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг* ***аль нэг ажилтанд хавсран хариуцуулна****. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1.Төсвийн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх.

2.Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Булган аймгийн Дашинчилэн сумын Цэцэрлэгийн эрхлэгч (Н.Алимаа), нягтлан бодогч (З.Отгонтуяа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ
"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙ АУДИТОР Ш.ГАНЧИМЭГ

Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 410 тоот өрөө, утас-70342716

6326090371